



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 90

Номгон

“Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III” аймгийн дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хоршоодын хамрах хүрээг өргөжүүлэн хөгжүүлэх, хөтөлбөрийн санхүүжилтийг орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд тусгаж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан үр дүнг тооцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Мөнхсайхан/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Байгальмаа/-д үүрэг болгосугай.



Б.БАТБАЯР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 09 дугээр сарын 14-ны
өдрийн 90 дугээр тогтоолын хавсралт

“ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ НИЙГМИЙН ХЭМЖЭЭНИЙ
ХӨТӨЛБӨР III” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг Засгийн газрын 1998 оны 145, 2009 оны 173 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж эхэлсэн. Мөн 2003 оныг “Хоршоог дэмжих жил” болгон зарлаж, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-I”-ийг 1998-2006 онд, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-II”-ийг 2009-2017 онд хэрэгжүүлсэн нь хоршооллын салбарын хөгжилд чухал түлхэц болсон.

Дээрх хөтөлбөрүүдийн хүрээнд хоршооны удирдлага, гишүүдийг олон улсын болон дотоодын холбогдох байгууллагаас зохион байгуулсан сургалт, арга хэмжээ, хуралд хангалттай сайн хамруулсан боловч хоршооныхоо үйл ажиллагаанд нэвтрүүлсэн шинэ санаа, санаачилга дутмаг, мөн аймаг дэд хөтөлбөр батлуулан хэрэгжүүлэх талаар тусгасан боловч батлуулаагүй, хоршоод орон нутгийн байгууллагатай хамтран ажиллагаагүй зэрэг дүгнэлтийг ХХААХҮЯ гаргасан.

Цаашид салбарын эрх зүйн орчныг сайжруулах, төсөв хөрөнгийг хангалттай батлан хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд орон нутаг, бусад төсөл хөтөлбөртэй уялдаатай ажиллаж салбарын хөгжлийн түвшинг шинэ шатанд гаргах шаардлагатай гэж зөвлөсөн байна.

Улсын хэмжээнд 2018, 2020 онуудад хоршооны үнэлгээг зохион байгуулсан.

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны удирдамжийн дагуу 2018 онд хоршоодод үнэлгээ хийгдсэн бөгөөд манай аймагт улсын бүртгэл бүхий 256 хоршоо байгаагаас 189 нь үнэлгээнд хамрагдсан.

Хоршоодын хөгжлийн үнэлгээний дүн (2018 он)

Ангилал	Хоршооны тоо	Эзлэх хувь
Үнэлгээнд хамрагдаагүй	67	26,1
Идэвхгүй буюу зогсонги	17	6,64
Идэвхжиж байгаа	95	37,1
Үйл ажиллагаа нь тогтвортежиж байгаа	44	17,1
Тогтвортой хөгжиж буй	33	12,8
Дүн	256	100


Үнэлгээнд хамрагдаагүй 60 гаруй хоршоодын үйл ажиллагаа нь тогтмолжоогүй, засаглалын үйл ажиллагаа сул, төрөөс бодлогын болон бусад хэлбэрийн дэмжлэг сул байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.

2. ХХААХҮЯ-ЖДҮХХБЗ Газрын даргын хоршооны хөгжлийг үнэлэх ажлын удирдамжийн дагуу хоршооны үнэлгээг зохион байгуулсан. Энэхүү үнэлгээ нь хоршооны давуу сул талуудыг илрүүлэн үйл ажиллагаа нь бизнесийн хөгжлийн аль шатанд явж байгаа цаашид анхаарах шаардлагатай асуудлуудыг тодорхойлон гаргаж ирэх зорилготой хийгдсэн.

Баянхонгор аймагт 2020 оны байдлаар бүртгэлтэй 280 хоршоо байснаас 120 нь буюу 42.8 %-д үнэлгээг хийж үлдсэн 160 нь буюу 57,2% нь ямар нэгэн байдлаар / үйл ажиллагаа явуулаагүй 3-аас дээш жил болсон, холбогдох хүмүүс гадагшаа явсан, хоршооны даргын бүртгэлтэй дугаар холбогдохгүй, байршил нь тодорхойгүй, нас барсан зэрэг/ холбогдож чадаагүй байна.

Үнэлгээ хийсэн хоршоодоос 25 үйл ажиллагаа түр зогссон, 57 үйл ажиллагаа бүрэн зогссон 38 нь хэвийн ажиллагаатай байсан.

Хөгжлийн түвшин



■ Идэвхигүй ■ Идэвхжиж буй ■ Хөгжиж буй ■ Тогтвортой ёсөлттэй

Иймд хоршооллын хөдөлгөөнийг түгээн дэлгэрүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлоготой нийцүүлэн хоршоог дэмжих, хуульд заасан зорилго, зарчимд нийцсэн хоршоог байгуулах, улсын бүртгэлд бүртгэх, хариуцлага, дотоод хяналтыг нь сайжруулах шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 362 дугаар тогтоолоор “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-III”-ийг батлан хэрэгжүүлж эхлээд байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, хоршоо, хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, хоршооны хөгжлийн эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх, нийгэмд гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, ажлын байрыг бий болгоход хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1. Салбар бүрийн хоршоодын хөгжлийг бодлогоор дэмжих, хоршоо хөгжих таатай орчинг бүрдүүлэх;

2.2.2.Хоршоог хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар ажлын байр нэмэгдүүлэх;

2.2.3. Хоршоогоор дамжуулан түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоог бий болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжих;

2.2.4.Хоршооны “Сайн засаглал”-ыг төлөвшүүлэн нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх.

2.3. Хөтөлбөрийг 2020-2024 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Хоршоодын хөгжлийг бодлогоор дэмжих, хоршоо хөгжих таатай орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

3.1.1. Аймаг орон нутгийн стратегийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулахдаа хоршооны хөгжлийн асуудлуудыг тусгаж байх

3.1.2.Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг үнэлэх ажлыг зохион байгуулж загвар хоршоог хөгжүүлэх

3.1.3. Аймгийн тэргүүний хоршоог шалгаруулах журмыг боловсруулж, шилдэг хоршоодыг жил бүр урамшуулах.

3.1.4. Төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авалтад орон нутгийн хоршоодыг давуу эрхтэйгээр оролцуулах боломжийг бүрдүүлэх

3.1.5. Сум агентлагийн удирдлагын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд хоршооны хөгжлийг дэмжсэн байдлыг шалгуур үзүүлэлт болгон оруулах

3.1.6. Төрийн зарим чиг үүргийг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын холбоодоор гүйцэтгүүлэх.

3.2. Хоршоог хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар ажлын байр нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

3.2.1. Хоршоог жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх сан болон орон нутгийн хөгжлийн сангийн хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих

3.2.2. Ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах, байгаль орчны чиглэлийн төсөл, хөтөлбөрт хоршоодын оролцоог нэмэгдүүлэх;

3.2.3. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгийн эх үүсвэрийг аймаг, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгаж шийдвэрлэх

3.2.4. Ашиглагдахгүй байгаа орон нутгийн өмчийн байшин барилга, объектыг хоршоодод үнэ төлбөргүй шилжүүлэх, гэрээгээр эзэмшүүлэх

3.3. Хоршоогоор дамжуулан түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоог бий болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд:

3.3.1. Хоршооны бүтээгдэхүүн борлуулалтын төв, хөдөө аж ахуйн болон жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийн дундын цэгийг орон нутагт байгуулж, хоршоодын захиалгын дагуу нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

3.3.2. Ажлын байр нэмэгдүүлэх болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүжилтийн тодорхой хэсгийг хоршооны салбарын үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжихэд зарцуулах;

3.3.3. Загвар хоршоог байгуулж, хөрөнгө санхүүгээр дэмжих;

3.3.4. Түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх;

3.3.5. Хоршоодын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.3.6. Үндэсний үйлдвэрт хоршоо бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх, харилцан ашигтай хамтран ажиллах тогтолцоог хөгжүүлэх;

3.3.7. Хоршоодын бэлтгэсэн малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжих ажлыг эрчимжүүлэх;

3.3.8. Түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг хоршооны бүтцэд тулгуурлан сумдад байгуулах.

3.3.9. Хоршоодын үйлдвэрлэсэн бүтээгдэгдэхүүнийг сурталчлах, туршлага судлах зорилгоор дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулах

3.4. Хоршооны “Сайн засаглал”-ыг төлөвшүүлэн нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1.Хоршооны удирдлага, гишүүдэд зориулсан тусгай хөтөлбөр бүхий байнгын сургалт зөвлөх үйлчилгээг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор үе шаттайгаар явуулах,

3.4.2. Хоршоодыг шинэчилсэн бүртгэлд хамруулж, цэгцэлж аймгийн мэдээллийн санг бий болгох,

3.4.3. Төр засгаас хоршооны хөгжлийг дэмжих чиглэлээр батлан гаргасан бодлогын баримт бичгийг нийтэд таниулах сурталчлах

3.4.4. Хоршооллын салбарын залуу үеийг дэмжсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хоршооны салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, залгамж үеийг төлөвшүүлэх,

3.4.5. Хоршооны гишүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, дотоод хяналтыг сайжруулах;

3.4.6. Орон нутгийн хоршооны асуудал хариуцсан төрийн албан хаагчид (улсын бүртгэгч, татварын байцаагч, аймаг сумын хоршоо хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан гэх мэт)-д хоршооны онцлогийг таниулсан сургалт зөвлөгөөг зохион байгуулах.

3.4.7. Хоршоог дэмжигч шилдэг төрийн түшээг сум, аймгийн түвшинд тодруулан өргөмжилж байх.

3.4.8. Хоршоологчдын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хоршооны ач холбогдол давуу талыг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах,

Дөрөв. Дэд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2019 он)	Зорилтот түвшин (2024 он)
1	Сургалтад хамрагдсан байдал	Тоо	7	40
2	Загвар хоршоо бий болох	сум/хоршооны тоо	0	10
3	Төрийн зарим чиг үүргийг хоршоо, хоршоодын холбоогоор гүйцэтгүүлсэн байдал	гүйцэтгэсэн ажлын тоо	0	10
4	Хоршооллын хөгжлийг дэмжсэн төсвийн санхүүжилтийн хэмжээ	төгрөг	600,000	25 000 000
5	Хоршоодод шилжүүлсэн болон гэрээгээр ашиглуулсан барилга байгууламж	Тоо	8	15
6	Хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	тэрбум төгрөг	0.5	0.7
7	Гишүүдийн тоо	тоо	8395	8500
8	Хоршооны борлуулалтын болон гишүүдэд хуваарилсан ногдол орлогын дүн	Хувь		
9	Түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төв	Тоо	5	10
10	Үндэсний үйлдвэрт нийлүүлсэн бүтээгдэхүүн, түүхий эд нийлүүлсэн хоршооны тоо	хоршооны тоо/ ёсёлтийн хувь	8	15/25
11	Биржээр түүхий эдээ арилжиж буй хоршоо	хоршооны тоо	0	10
12	Аймгийн шилдэг хоршоо	Тоо	5	10
13	Төсвийн хөрөнгөөр бараа бүтээгдэхүүн худалдан авалтад орсон хоршоодын тоо	Тоо	9хоршоо, 148 сая	15 хоршоо, 250 сая гаруй
14	ЖДҮХС, СХС, ХЭДС, ОНХС зэргээс олгосон хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодын тоо, дүн	Тоо	20 төсөлд-213.5 сая	40с доошгүй төсөлд 500с дээш сая төгрөг

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 5.1.1. Орон нутгийн төсөв;
- 5.1.2. ЖДҮХС-гийн хөрөнгө;
- 5.1.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө
- 5.1.4 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө
- 5.1.5 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө
- 5.1.6 Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө
- 5.1.7 Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусlamж, төсөл хөтөлбөр;
- 5.1.8. Бусад эх үүсвэр;

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг орон нутагт салбар, зөвлөл хариуцна. Орон нутгийн салбар зөвлөлийг аймгийн Засаг дарга тэргүүлж, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж гаргана. Сумдад хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг Сумын Засаг дарга тэргүүлэх ба салбар зөвлөл ажиллуулна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд сумын Засаг даргын Тамгын газрын хоршоо хариуцсан мэргэжилтэн, хоршооны удирдлага, хоршооллын хөдөлгөөнийг дэмжигч байгууллагуудын төлөөлөгчийг оролцуулна. Сумд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор баталсан журмын 7.6-д заасны дагуу хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тайланг заасан хугацаанд холбогдох газруудад хүргүүлнэ.

7.2. Шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ.